



МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,221,591...



2018.08.28. Мягмар. №143 (4993)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

Худалдах үнэ 500 төг



www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongollinmedeesonin@gmail.com

- "Дэлхийн сонины холбоо"-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Нэргүйн ПУНЦАГБОЛД

МЭДЭЭЛЭЛ

ҮЗЭЛ БОДОЛ

Төмөр замын ажилтан галт тэргэнд дайруулж, амиа алджээ

Б.ПҮРЭВЖАВ

"УБТЗ" ХНН-т хариуцлагагүйн зуд нүүрлэжээ. Өчигдөр өглөө 10.00 цагийн үед Замын-Үүд өртөөнд Төмөр замын холбогч ажилтан олон улсын галт тэргэнд дайруулж, нас барсан аж. Одоогоос сарын өмнө УБТЗ-д ийм асуудал гарч байлаа. Гэвч үйлдвэрийн осол гэсэн шалтгаанаар хэргийг хаасан талаар эх сурвалж хэлж байсан юм. Энэ талаар УБТЗ-ын дарга Д.Жигжиднямаагаас тодруулж, асуух гэсэн ч утсаа авсангүй. Харин хэвлэлийг төлөөлөгчөөс нь тодруулахад, "Ээлжийн амралт дуусаагүй. Ажилдаа ороогүй байна" гэсэн тайлбар өглөө. Мөн Замын-Үүдийн Цагдаагийн хэлтэстэй холбогдоход "Манайд ямар ч мэдээлэл алга. Ээлжийн амралт дуусаад өнөөдөр ажилдаа орлоо. Тэгээд ч утсаар мэдээлэл өгөхгүй. Ирж уулзах ёстой" гэсэн тайлбар хэлсэн юм.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Ц.ЦОГЗОЛМАА:

Боловсролын салбар хичээлийн шинэ жилд бэлэн



Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ
ts.chandmanierdene@gmail.com

Бүх шатны боловсролын байгууллагад "Суралцагч бүрийн сурлагын чанарыг сайжруулах" жил болгох зорилго тавьсан БСШУСЯ-ны газрын дарга нар салбарын сайдын хамт өчигдөр өргөтгөсөн хэвлэлийн хурал хийлээ. Хэвлэлийн хурлын үеэр Ц.Цогзолмаа сайд ирэх хичээлийн шинэ жилд ямар зорилгын дор ажиллах талаараа мэдээлэл өгсөн бөгөөд цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн тавьсан асуултад хариулсан юм.

Үргэлжлэл нь VI нүүрт



Б.ӨНӨРТОГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

Хэнтийчүүд азгүй юм. Улсын наадмын торгон дэвжээнд манлайлж явсан ч улс төрд "од нь гийж", тод гэрэлтээгүй Б.Бат-Эрдэнэ аваргыг УИХ-д төлөөлөө болгож явуулснаас хойш л энэ аймгийг улстөрчийн тэнгэр хаясан бололтой. Эмэгтэй улстөрчдийн төлөөлөл болох экс гишүүн Д.Арвин ч өр лүү нь өшиглөхөөд Баянзүрх дүүргэгт вант улсаа байгуулахаар давхиж одсон түүх бас бий.

Үргэлжлэл нь III нүүрт



Миний биеийг УИХ-ын гишүүн, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга болсноос эхлээд урд өмнө нь үүсгэн байгуулж, хийж бүтээсэн ажил бүтээн байгуулалтыг маань үгүйсгэх, мушгин гуйвуулах явдал хэрэв хэтэрлээ. УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын ажлыг ашиг сонирхлын зөрчилтэй хийж байгаа мэтээр дайрч давшлах, эх орноосоо урвасан мэтээр зохион байгуулалттайгаар, захиралтайгаар гүтгэсэн, доромжилсон мэдээллийг зориудаар тараах боллоо. Өмнө нь тухай бүрт тайлбар өгч, нийгэмд мэдээлж явсангүй. Гэсэн ч гүтгэгчид улам бүр дайрч доромжлох болов. Өнгөрсөн долоо хоногт гэхэд л "Дэлхийн Монгол" хэмээх Төрийн бус байгууллагын Бээжин, Алтангэрэл зэрэг хүмүүс Туул голыг уйлуулж байна, бохирдуулж байна хэмээн 15 минутын турш мэдээлэл хийхдээ Ц.Гарамжав гэдэг нэрийг 20-30 удаа илтгэд гүтгэн доромжлохын тулд хэлж, УИХ-ын гишүүний нэр төрд халдлаа. Иймээс бодит мэдээллийг хариуцлагатай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан өгөхийг зорилго.

МЭДЭГДЭЛ

Анх 1996 онд Засгийн газрын шийдвэрээр тендер зарласны үндсэн дээр Канадын "Заамар гоулд" компани Тосонгийн ордыг ашиглах эрхийг эзэмшсэн. Үүний дараа "Монполимет" компани 60 хувийг эзэмшижээ болж, хөрөнгө оруулалт хийх, босгох асуудлыг хууль эрхийн дагуу явуулж эхэлсэн. Тосонгийн голын гольдролыг ашиглах төслийг хамтран эзэмшиж, дэлхийн төвшинд олон мянгаараа ажилладаг байгаль орчинд ээлтэй драгийн үйлдвэрлэлийг барьж байгуулж, техник технологийг нэвтрүүлж хөрөнгө оруулалтыг босгосон. Ингэхдээ Монгол Улсын ашигт малтмалын тухай хууль болон цаг үеийн өөрчлөлтүүдийг баримтлан Засгийн газраас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу онцгой хамгааллын бүсэд ажиллаж байгаа болно. Драгийн үйлдвэрүүд нь Туул голын ойролцоо нуур байгуулан үйлдвэрлэлийнхээ усны 70 хувийг тогтмол ашиглан, 30 хувиа сэлгэж ажилладаг технологитой. Шаардлагатай үед уулын ажлын төлөвлөгөөнд тусган тухайн орон нутгийн байцаагч, байгаль орчны хамгаалагч нарын хяналт доор багтуулсан төлөвлөгөөний дагуу голыг хөндлөн гарч, нэг цэгээс нөгөө цэгт шилжин ажиллах технологитой байдаг. Гол гарч байх үед ямар нэгэн ашигт малтмал олборлодоггүй болно. Энэ талаар үйл ажиллагаа явуулж байгаа холбогдох компани нь дэлгэрэнгүй тайлбар, нотолгоогоо удахгүй хийх байх.

Уул уурхайн үйлдвэрлэл нь байгалийн төрөл бүрийн орчин нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг. Устай нөхцөлд ч, хад чулуутай нөхцөлд ч ажиллах шаардлагатай болдог. Хамгийн чухал нь байгаль орчноо аль болохоор байгаагаас нь илүү буюу нийгэмд ач холбогдолтой эдийн засгийн эргэлтэд оруулахад боломжтойгоор явуулах байдаг.

2009 онд Урт нэртэй хуулийг УИХ баталсан. Үүний дараа Засгийн газрын 130, 199 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтаа хийсэн, үйлдвэрүүдээ барьж байгуулсан, ашиглалт, үйл ажиллагаагаа жигд тогтмол явуулах үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн онцгой хамгаалалтын бүсэд ажиллах зөвшөөрлийг баталгаажуулж өгсөн. Үүний дагуу Усны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан Онцгой хамгаалалтын бүс буюу 50 метрийн зайг баримтлан "Монросцветмет", "Алтандорнод Монгол", "Монполимет"-ийн

драгийн үйлдвэрүүд Туул голын адагт 12-24 дэх жилдээ ажиллаж байна. "Монполимет" компанийн хувьд 12 дахь жилдээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа уул уурхайн хууль эрх зүйн орчинд бүрэн нийцүүлэн явуулж байна. Анх Драгийн үйлдвэрлэлийг манай улс 1972 онд Толгойтын Ерөөгийн голын гольдролд улсын үйлдвэрийн газар болох "Монросцветмет" барьж байгуулж, үйлдвэрлэлээ явуулж ирсэн түүхтэй. Драгийн үйлдвэрлэлийг энгийнээр тайлбарлахад голын татан болон гольдролд үүссэн ашигт малтмалын ордыг ашиглахад зориулсан баяжуулах үйлдвэр юм. Драгийн үйлдвэрлэл нь байгаль орчны нөхөн сэргээлтийнхээ 60 хувийг өөрөө хийдэг, цахилгаан хөдөлгүүртэй бүрэн автомажсан үйлдвэр юм. Миний үүсгэн байгуулсан "Монполимет" компани нь Монгол Улсын хууль тогтоол, дүрэм журмыг бүрэн дүүрэн мөрдөж жил бүр Мэргэжлийн хяналт болон холбогдох яамдаар үйлдвэрлэлийн ажил явуулах талбайн төлөвлөгөө норм, гүйцэтгэлийн ажлаа батлуулж, хэрэгжүүлэн тайлагнадаг. "Монполимет" компани Монгол Улсдаа анхны жишиг загвар болох байгаль орчны нөхөн сэргээлтийг бий болгож, улс орон нутгийн хэмжээнд хэмжээний нөхөн сэргээлтийн сургалтуудыг явуулж, их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэжлийн уул уурхайн компани гэдгээ батлан ажиллаж явна. Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны багц хуулийг нэг бүрчлэн хэрэгжүүлж Монгол Улсын уул уурхайн салбар тулгараад байгаа байгаль орчны нөхөн сэргээх үйл ажиллагааны жишиг загварыг тогтоон ажиллаж байна.

Гэтэл цахим сүлжээгээр мэдээллийг хяналтгүйгээр цацагч болсныг буруутгаар ашиглаж, бодит бус гүтгэлийн шинжтэй мэдээллийг зоринд санаатайгаар олон давтамжтайгаар цацах гэмт хэргийн шинж чанартай үйлдэл газар авах боллоо. Энэ нь хүний эрх болон УИХ-ын гишүүний эрхийг зөрчиж байна гэдгийг мэдэгдье. Энэ хэргийг мэргэжлийн байгууллага хууль, хяналтын байгууллагууд шалган харинг олон нийтэд мэдээлэхийг хүсье.

УИХ-ЫН ГИШҮҮН Ц.ГАРАМЖАВ

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

PHOTO NEWS

МЭДЭЭЛЭЛ

АШУУИС багш нар сайддаа шаардлага хүргүүллээ

Б.БУНДХОРОЛ

“Монгол ньюс” мэдээллийн төвд очигдөр “АШУУИС-ийн тогтвортой хөгжил багш ажилчдын түр хороо”-ноос Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд үүсээд буй нөхцөл байдлын талаар хэвлэлийн хурал хийлээ. Түр хорооны зүгээс тус сургуулийн захирлын орон тоонд сонгон шалгаруулалт зарлалгүй, хууль бусаар шинэ захирал томилсон, шинээр ирсэн захирал Ж.Цолмон өөрийн багийг бүрдүүлэх нэрийн дор удирдах төвшний боловсон хүчнийг халж, сольж буйг эсэргүүцэж буйгаа илэрхийлсэн юм. Тиймээс Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, БСШУС-ын сайд нарт шаардлага хүргүүлж байгаа аж. Тус шаардлагад дараах гурван зүйлийг шаарджээ. Нэгдүгээрт, Намын томилгоо гэх нэрээр хамт олны хүсэл сонирхлыг үл ойшоон төрийн нэрийг барьж, хүч түрэн танил тал, найз нөхдөө албан тушаалд томилсон энэ бусармаг үйлдлээ нэн даруй зогсоох. Хоёрдугаарт, Боловсролын байгууллагын хуулиар олгогдсон хараат бус академик эрх чөлөөг хангах, эрдэмтэн багш нар ажилтан ажилчид, оюутан залуусын хүсэлтийг хүндэтгэн үзэх. Гуравдугаарт, Энэ оны есдүгээр сард багтаан Их сургуулийн удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох хүртэл их сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөхгүй байхыг тус тус шаардсан байна. Мөн шаардлагын хариуг наймдугаар сарын 30-ны дотор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр ирүүлэхийг шаарджээ. Хэвлэлийн хурлын дараа түр хорооныхон БСШУС-ны үүдэнд жагсаж, эсэргүүцлээ илэрхийллээ.



“Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо”-ноос очигдөр “1000 цүнх” чээллэнж хөтөлбөрийг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаа гурав дахь жилдээ болж байгаа аж.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Д.Хадхүү: Гэрээт малчны төсөлд 520 гаруй гэр бүл хамрагдах боломжтой



Б.ПҮРЭВЖАВ b.puuji11@gmail.com

Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг 2018-2021 оныг дуустал хэрэгжүүлэхээр болсон билээ. Энэ хүрээнд “Гэрээт малчин-өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Зохион байгуулалттай ажлын байр” гэсэн төслүүдийг хэрэгжүүлэхээр болсон юм. Энэ талаар ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Д.Хадхүүгээс тодрууллаа.

“Гэрээт малчин-өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийг ХНХЯ-наас эхлүүлж байгаа. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу? -Хуулийн дагуу Хөдөлмөрийн дэмжих сангийн хөрөнгөөр тодорхой төслүүдийг хэрэгжүүлдэг. Үүнд нийтийг хамарсан ажил, мэргэжлийн түр сургалтын төв, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэх мэт олон янзын хөтөлбөр төслийг хэрэгжүүлдэг. Энэ оны хувьд ХНХ-ын сайдын санаачилгаар гэрээт малчин, зохион байгуулалттай ажлын байр бэлтгэх гэсэн хоёр төсөл

хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр багтлуулсан. Тухайлбал, шинээр нэмж хоёр туршилтын төсөл хэрэгжүүлж байгаагийн нэг нь гэрээт малчны төсөл гэсэн үг. -Гэрээт малчнаар бүртгүүлбэл хаана хандах ёстой вэ? -Гэрээт малчны төслийг хэрхэн хэрэгжүүлэх, ямар заавар зөвлөгөөгөөр явах эсэхийг нь тодорхой нэр дурьдагдсан аймгуудын Засаг дарга нарт хүргүүлсэн. Гэрээт малчин гэдэг нь тодорхой хэмжээнд орон нутгаас буюу аймгаас сумандаа очиж ажиллах хүн юм. Ингэхдээ тухайн хувь хүний судалгаа байх ёстой. Мөн ажил олгогч малчны судалгаа байх юм. Ингээд хоёр талын судалгааг аймгуудын хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл, аймгуудын хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүсэлтээ гаргана.

“Хувь хүн хүсэлтээ гаргаад тэнцлээ. Ажил олгогч нь бэлэн. Энэ тохиолдолд төрөөс ямар нэгэн дэмжлэг бий юу? -Аймгаас сум руу хүрэх зардлыг төрөөс олгоно. Тодруулбал, 50-200 км-т нүүвэл 150, 200-350 км-т 350, 351-500 км-т 500 мянган төгрөгийн зардлыг олгох юм. Үүнд хоёроос доошгүй гишүүнтэй гэр бүл байж болно гэж заасан. Мөн нийгмийн болон эрүүл даатгалын шимтгэлийг төлөх гэх мэт боломжийг төрөөс олгож байна. -Гэрээт малчинд ямар

шаардлага тавих вэ? -18-59 насны гэр бүл. Хоёроос доошгүй гишүүнтэй байна. Мөн хоёроос доошгүй жил гэрээт малчнаар ажиллах хүсэлт гаргасан байх ёстой. -Ажил олгогч малчинд ямар шаардлага тавьж байгаа вэ? -800-гаас дээш толгой малтай байна. Хамгийн чухал нь гэрээгээр малчин ажиллуулах хүсэлт гаргасан байх ёстой. Ажил олгогч сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй цалин хөлс олгоно. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хоёр гишүүнийг цалинжуулахаар гэсэн үг. Тухайн гэрээт малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулна. Хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлыг хангана. -Төсөл хэдэн аймагт хэрэгжих вэ? -Аймаг бүр харилцан адилгүй байгаа. Зарим нь аймагт гэрээт малчны төсөл хэрэгжиж байгаа бол үлдсэн хэсэгт зохион байгуулалттай ажлын байр бэлтгэх төсөл хэрэгжиж байна. Гэрээт малчны төсөл 12 аймагт хэрэгжинэ. Тухайлбал, Говь-Алтай, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Төв, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь гэх мэт аймагт хэрэгжих юм...

...Зарим нь аймагт гэрээт малчны төсөл хэрэгжиж байгаа бол үлдсэн хэсэгт зохион байгуулалттай ажлын байр бэлтгэх төсөл хэрэгжиж байна. Гэрээт малчны төсөл 12 аймагт хэрэгжинэ. Тухайлбал, Говь-Алтай, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Төв, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь гэх мэт аймагт хэрэгжих юм...

хүлээлгэн өгөх юм. Энэхүү аяны тугийг Дотоод хяналт шалгалтын хэлтсээс бааз, хэлтсийн удирдлагуудад хүлээлгэн өгч байгаа бөгөөд өнөөдөр “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын ТТБТХ-ийн хэлтсийн дарга, Ерөнхий инженер Б.Энхцаг, инженер техникийн ажилчдын хамт аянд нэгдэн ирээдүй болсон үрсийнхээ оюуны ертөнцөд өнгө нэмэхээр тугийг гардан авсан юм.

Шинэ цэвэрлэх байгууламж хоногт 250 шоо метр талбайг цэвэрлэнэ

Б.ПҮРЭВЖАВ

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл-ийн нээлт боллоо. Орчин үеийн шинэ дэвшилтэт технологи бүхий шинэ цэвэрлэх байгууламж нь хоногт 250 мянган шоо метр буюу одоо ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжаас хоёр дахин илүү бохир цэвэршүүлэх хүчин чадалтай. Лагийг боловсруулан гаргаж авсан метан хийгээр байгууламжийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах юм. Мөн цэвэршүүлсэн усыг үйлдвэрлэлд нэвтрүүлж ДЦС-3, ДЦС-4 хөргүүрт ашиглан зүүн бүсийн усны хэрэгцээнд нэвтрүүлэх тооцоотой байгаа юм. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд “Шинэ цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтыг хавар газар гээсх үеэр эхлүүлэх хүлээлттэй байна. Ажил эхлээд 1.6 жилийн хугацаанд барьж дуусах тооцоотой. Улаанбаатар хотын ойрын ирээдүйн бүх хэрэгцээг хангасан цэвэрлэх байгууламж босно. Бид хуучин цэвэрлэх байгууламжийн техник, технологийг ч сайжруулахаар зорьж байна” гэж хэллээ. БНХАУ-ын талаас гурван компанийг сонгон шалгаруулсан байна. Уг компаниудад Хятад улсын Экзим банк үнэлгээ хийж байгаа бөгөөд үүний дараа манай талд мэдэгдэл хүргүүлсний дагуу сонгон шалгаруулалт явуулна. Шалгарсан компани манай улсаас 4-5 туслан гүйцэтгэгч компанийг шалгаруулна. Монгол Улсын зүгээс тендер зарлахдаа 2020 он гэхэд цэвэрлэх байгууламжийг хүлээлгэн өгнө гэсэн нөхцөл тавьж байгаа юм байна.

НИЙГЭМД ЦӨӨН МӨРӨӨР

- БНХАУ-ын ЭСЯ-ны гадна сургуульдаа явахаар виз хүссэн оюутны дараалал үүсээд байгаа. Тэгвэл манай Гадаад харилцааны яамнаас сургуульдаа бүртгүүлэх тов нь тулгамдсан шинэ оюутнуудын асуудлыг БНХАУ-ын ЭСЯ-нд төлөөний нотоор тавьсан байна.
- Өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангасан аймгийг 15, малчдыг гурван сая төгрөгөөр шагнана.
- “Хүүхдийн хөгжилд өнцөг эхийн оролцоо” зөвлөгөөн болж өндөрлөлөө. Зөвлөгөөнд есөн дүүргийн 165 өнцөг эхийн төлөөлөл, 20 гаруй багш оролцжээ.
- Монголын зохиолчдын эвлэлийн ээлжит бус чуулган хуралдаж, Удирдах зөвлөлийн даргаа сонгожээ. Удирдах зөвлөлийн даргын сунгаанд Д.Нацагдоржийн шагналт зохиолч М.Эрдэнэбат, Соёлын гавьяат зүтгэлтэн зохиолч Д.Цэнджав, Р.Чойномын өвийг хамгаалах “Өд” сангийн тэргүүн, доктор Д.Ганболд нар өрсөлдөж, олонхийн саналаар Д.Цэнджав сонгогдсон байна.

МЭДЭЭЛЭЛ

1, 2 дугаар бааз хүүхдийн ертөнцөд өнгө нэмэв

Б.ПҮРЭВЖАВ

Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сурч боловсрох, сэтгэхүйг хөгжүүлэх, танин мэдэхүйн орчинг бүрдүүлэх зорилготой “Хүүхдийн ертөнцөд өнгө нэмье” аяны туг өнгөрөгч сарын 10-наас энэ сарын 23-ны хооронд 1, 2 дугаар баазад аялалаа. Аяны хүрээнд ажилчид дуу, үлгэр, түүхийн болон буддаг, зурагт

ном, тоглоом, өөрсдийн хийсэн эсгий урлалын үлгэрийн цомгоо цэцэрлэгийн бяцхан хүүхдүүдэд сэтгэлийн бэлэг болгон өгсөн юм. Ажилчдын өгсөн энэхүү тоглоом, ном, гараар урласан бүтээлийг аян өндөрлөсний дараа “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын хамтран ажилладаг 94 дүгээр цэцэрлэг болон хоёрдугаар баазын ажилчдын “Бүтээлч багачууд” цэцэрлэгийн хүүхдүүдэд

хүлээлгэн өгөх юм. Энэхүү аяны тугийг Дотоод хяналт шалгалтын хэлтсээс бааз, хэлтсийн удирдлагуудад хүлээлгэн өгч байгаа бөгөөд өнөөдөр “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын ТТБТХ-ийн хэлтсийн дарга, Ерөнхий инженер Б.Энхцаг, инженер техникийн ажилчдын хамт аянд нэгдэн ирээдүй болсон үрсийнхээ оюуны ертөнцөд өнгө нэмэхээр тугийг гардан авсан юм.

Information box containing contact details for MMDARDAS, including phone numbers, email addresses, and social media links. It also features the logo of the Mongolian Media Association.

МАН, Р.БУРМАА ХОЁРЫН ХЭН НЬ БУРУУТАЙ ВЭ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хамгийн сүүлд сонгож явуулсан залуу улстөрч нь харин хүчингийн хэрэг үйлдсэн хэрэгт сэжиглэгдэж, гишүүний суудлаасаа буулаа. Хэзээ хэзээнээс л улстөрчийн сонголтоо буруу хийж байсан хэнтэйчүүд энэ удаа бүр төрд төлөөлөх улстөрчгүй болж үлдэх нөхцөл байдал бий болоогдов. Учир нь Д.Гантулга гишүүний орыг залгаж, хэнтийчүүдийн төлөөлөл болж суух УИХ-ын гишүүнийг сонгох учиртай нөхөн сонгуулийн тов нэг жилээр хойшлох нөхцөл байдал бий болжээ. Дээд шүүхэд бүртгэлтэй 13 намын дарга өрсөлдсөн, мөн тооны бие даагч өрсөлдөхөөр бүртгүүлсэн түүхэнд бичигдэх нөхөн сонгууль болно гэсэн хүлээлт ч талаар өнгөрч байх шиг. Ардчилсан парламенттай болсон 28 жилийн хугацаанд ямар ч нөхөн сонгуульд ийм олон нэр дэвшигч өрсөлдөж байсан түүх байхгүй биз. Угтаа улс төрийн хоёр гол хүчин болох АН, МАН-ын аль аль нь санал хуваах үүднээс парламентад суудалгүй намуудыг хоёр талцуулан хувааж авчихаад “тулагдах” нөхцөл байдал бий болоод байлаа. За энэ ч яах вэ, өнгөрсөн асуудал. Хамгийн гол нь нөхөн сонгуулийг хойшлуулах нөхцөл байдал юу байв гэдэг л энэ өдрүүдэд хэвлэл мэдээллийн шүүрэх гол сэдэв болчихоод байгаа юм. Улс төрийн нам, бие даагчид хүртэл улстөржсөн мэдэгдэл хийж, “Би яг нөхөн сонгуульд орж ялах гэж байхад МАН, АН айчихлаа. Энэ бол ард түмний сонголт болох байсан” хэмээн пиардаж суугаа. Нөхөн сонгуулийг аравдугаар сарын 07-нд зарлах ёстой гэсэн УИХ-ын тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн гэх Цэцийн шийдвэр хэнтийчүүдийг 2020 оны сонгууль хүртэл УИХ-д хоёрхон төлөөлөлтэй байх шалтгаан болох нь. С.Мөнхцэцэг, Н.Оюун нарын иргэдээс ирүүлсэн гомдлыг Цэц хянаж үзээд, УИХ-ын гаргасан тогтоол нь Үндсэн хуулийг зөрчжээ гэж үзлээ. Энгийнээр тайлбарлавал төрийн албан хаагч Нараа, Сараа энэ сонгуульд өрсөлдөх хүсэлтэй байжээ. Гэтэл төр сонгох, сонгогдох эрхийг нь шууд зөрчсөн, мөн “Үндсэн хуульд төрийн гаргасан бүх шийдвэр бүрэн нийцэх ёстой” гэсэн Үндсэн хуулийн 70.1 дэх заалтыг зөрчиж, улмаар нөхөн сонгуулийг нэгхэн сарын хугацаанд товлоод, шууд явуулахаар санаархлаа хэмээн Цэцэд хандсан юм. Харин Сонгуулийн тухай хуульд төрийн албан хаагч сонгуульд өрсөлдөхийг хүсч байвал зургаан сарын өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ өгөх ёстой гэж заасныг ч УИХ зөрчжээ. Мөн нөхөн сонгуулийг тухайн оны аравдугаар болон зургадугаар сарын эхний ням гарагт хийх ёстой гэж хатуу тусгаад өгчихсөн байдаг. УИХ уг нь хуулиа дагаж аравдугаар сарын эхний долоо хоногт зарласан ч төрийн албан хаагч нэр дэвшихийн тулд ажлаас чөлөөлөгдөх ёстой гэсэн өөр нэг заалтыг

таг мартчихсан гэсэн үг. Ийм л бантанг улстөрчид зуурч орхичихоод хаврын чуулганаа завсарлуулж, найр наадам хэсээд олодохгүй байгаа аж. Хуулиа дагаж мөрддөг шударга иргэний хувьд УИХ-ын гаргасан шийдвэр байж боломгүй алдаа, нийт төрийн албан хаагчдын эрхийг зөрчсөн ноцтой асуудал. Цэцэд хүсэлт гаргасан С.Мөнхцэцэг ч ингэж тайлбарлаж, үндэслэлээ хамгаалсан юм билээ. Тэрбээр, “Би тухайлбал нэр дэвшмээр байна. Гэтэл төрийн албан хаагч нэр дэвших эрхийг хаачихлаа” гэсэн утгатай үг хэлжээ. Харин үүнийг нь буруутгах, нэг намын захиалгаар ажилласан гэсэн хардлага намын дарга нар, улс төр судлаачид, хуульч нараас гарч эхэллээ. Тухайлбал, “Веритас партнерс” хуулийн фирмийн өмгөөлөгч, хуульч Б.Мэргэн “Хэнтийн нөхөн сонгуулийн товгыг зарласан УИХ-ын тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн гэж Цэцэд мэдээлэл гаргасан С.Мөнхцэцэг өөрийгөө төрийн албан хаагч учраас нэр дэвшиж чадахгүй болсон нь сонгогдох эрх зөрчигдөж байна гэсэн. Тэгээд “Хэзээнээс улс төрд орох, нэр дэвших тухай бодож эхэлсэн бэ” гэсэн Цэцийн гишүүний асуултад “Дөрвөн жил тутам сонгууль болсны дараа төрийн албан хаагчид халагдах эрсдэлд ордог. Би ч хохирогч болж байсан. Тиймээс халагдахгүйн тулд өөрөө гишүүн болчихъё гэж эртнээс бодох болсон гэв” хэмээн өөрийн нүүр номондоо бичсэн байв. Мөн АН, ИЗНН, МНН, ХҮН, МҮАН-ын дарга нар ч хэвлэлд өгсөн ярилцлагадаа “МАН-ын захиалга” хэмээн дүгнэснээ ч нуугаагүй. Цэцийн дээр хөх тэнгэр биш улс төрийн нам, хүчин суучихсан гэдэгт бат итгэлтэй болсноо ч тэд ярьсан байх юм. Харин МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга энд арай өөр тайлбар хийлээ. МАН нөхөн сонгуульд оролцох бэлтгэлээ базааж, бүр ялна гэсэн итгэлтэй байсан аж. Гэвч экс гишүүн Р.Бурмаагийн баталсан хуульд “Нөхөн сонгуулийг тухайн жилийнхээ арав, эсвэл зургадугаар сарын эхний ням гарагт явуулна” хэмээн хатуу заачихсан. Тиймээс Цэц нэгэнт шийдвэр гаргасан учраас ирэх жилийн зургадугаар сарыг хүлээхээс өөр аргагүй гэсэн тайлбар өгөв. Нэг үгээр хэлбэл, МАН нөхөн сонгууль хойшилсон бурууг Р.Бурмаад тохчихлоо. УИХ-д 65 суудалтай МАН-ынхан хуулиа маш сайн мөрдөж аравдугаар сарын эхний ням гарагт зарласан хэрэг л дээ. Харин өөр нэг чухал заалт болох “Төрийн албан хаагч нэр дэвшихийн тулд зургаан сарын өмнө ажлаа өгнө” гэх заалтыг хэнэггүй байдлаасаа болж мартав уу, эсвэл хэн нэгэнд үлдээж санаатай орхив уу гэдэг бас л сонихон. Хэрвээ МАН хүссэн бол Цэцийн гаргасан шийдвэрийг аравдугаар сар гарахаас өмнө ээлжит бус чуулган зарлаж хэлэлцээд, хүсвэл Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулчих боломж бий. Энэ байтугай асуудлыг өдрийн дотор хэлэлцээд өөрчилж

чаддаг улс. Гэвч хүсэл тэдэнд байсангүй. “Намрын чуулганы нээлт хүлээнэ ээ, ирц бүрдэхгүй хэцүү байна аа” хэмээн хөмсөг зангидаж суусаар аравдугаар сар гаргаж чуулганаа хуралдуулах нь нэгэнт тодорхой байна. Ингэснээр Цэцийн шийдвэр дашийн шог болж, хэнтийчүүдийн цөөнгүй хэсэг нь төрд төлөөлөгч бүтэн жил болох юм. УИХ хуралдаж Цэцийн шийдвэрийг

хүлээж авсан тохиолдолд Сонгуулийн хуулийг өөрчлөх учиртай. Хүлээж авахгүй бол Цэц дахиад хуралдана. Бүр Их суудлын хуралдаан зарлана. Ингэж бантан хутгаж явсаар ирэх сонгууль хүргэх сонирхол сөрөг хүчин, парламентад суудалгүй намууд гэхээс илүү эрх баригчдад байгаа гэдэг нь нуух аргагүй үнэн л дээ. Д.Амарбаясгалан генсеккийн хэлсэн шиг “МАН нөхөн

сонгуульд маргааш ч хамаагүй оролцоод ялна” гэсэн итгэл одоогоор алга. Улс төрийн нөхцөл байдал, нам доторх уур амьсгал таагүй болсон энэ үед бүлэг фракцийн зөрчил ч чинээндээ тулчихлаа. Нам дотроо зөрчилдөөнтэй хэвээр нөхөн сонгуульд орлоо гэхэд ялагдах магадлал 50-иас дээш хувьтай. Хэрвээ ялагдвал 2020 онд МАН-ынхан хуйгаараа ялагдах суурь тавигдах учраас сонгуулийг хойшлуулах эрх

ашиг юу юунаас илүү эрх баригч намд байгаа. Тиймдээ ч хаана ажиллаж, юу хийж яваа нь мэдэхгүй экс гишүүн Р.Бурмаа энэ завхралдаа буруутгаж, түүнээс алдааг хайх нь эрх баригч 64 улстөрчийн гаргах ёсгүй лав биш юмсан. МАН, Р.Бурмаа хоёрын хэн буруутайг шүүхээс илүүтэй, нөхөн сонгуулийн тойрсон зөрчлийг арилгах нь юу юунаас чухал болчихоод байна.



...Хэрвээ МАН хүссэн бол Цэцийн гаргасан шийдвэрийг аравдугаар сар гарахаас өмнө ээлжит бус чуулган зарлаж хэлэлцээд, хүсвэл Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулчих боломж бий. Энэ байтугай асуудлыг өдрийн дотор хэлэлцээд өөрчилж чаддаг улс. Гэвч хүсэл тэдэнд байсангүй. “Намрын чуулганы нээлт хүлээнэ ээ, ирц бүрдэхгүй хэцүү байна аа” хэмээн хөмсөг зангидаж суусаар аравдугаар сар гаргаж чуулганаа хуралдуулах нь нэгэнт тодорхой байна...

ӨДРИЙН ҮЙЛ ЯВДАЛ



...УИХ-ын гишүүн асан, Барилга хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгийн “Алтай” хотхоноос их хэмжээний мөнгө хувьдаа завшсан хэргийг шүүхэд шилжүүлсэн бол мөн л Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байсан Р.Эрдэнэбүрэн нь ажиллах хугацаандаа өөрийн ах дүү, хамаатан садны нэр дээр “River garden» цогцолбор хотхоноос 1.141.800.000 төгрөгийн үнэтэй 344.8 мкв талбай бүхий орон сууцыг худалдан авч үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс цагаатгаж шийдвэрлэсэн талаар мэдэгдэв...

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ УДИРДЛАГУУД 5.8 ТЭРБУМЫН ТЕНДЕРИЙГ ХУВЬДАА ЗАВШЖЭЭ

Б.ӨНӨРТӨГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

АТГ-аас сар бүр хийсэн ажлаа тайлагнадаг билээ. Тэгвэл энэ сарын хэвлэлийн хуралд Олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан, комиссар Т.Мөнхтунгалаг, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү, Мөрдөн шалгах хэлтсийн дарга Э.Идэрцог нар оролцож, мэдээлэл өгсөн юм. Тус байгууллагад өнгөрсөн хугацаанд төрийн албан хаагчид танил талаа албан тушаалд томилогдож, мөн авлига авдаг, төрийн жинхэнэ албан хаагчийн оронд үүрэг гүйцэтгэгч томилогдож гэх мэт олон санал гомдол ирсэн байна. Энэ хүрээнд Засгийн газарт 155 чиглэл бүхий зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгажээ. Гэсэн ч төрийн албан хаагчид зөвлөмж хэрэгжүүлээгүй, урьд өмнө гарсан зөрчил дутагдлаа засаагүй, бүр албан тушаалаа урвуулан ашиглаж бусдад давуу эрх олгож байсан олон ноцтой зөрчил илэрсэн аж. Өнгөрсөн хугацаанд цөөнгүй албан тушаалтнуудын авлига, албан тушаалын хэргийг илрүүлсэн гэв. Тухайлбал, Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга Э.Цэнд, Увс аймгийн Малчин сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Цэрэнхүү нар ашиг сонирхлын зөрчил гаргасан байж болзошгүй хэмээн шалгаж эхэлжээ. Мөн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогыг үнэн зөв мэдүүлэх үүргээ биелүүлээгүй Сэлэнгэ аймгийн Автотээврийн төвийн дарга Ж.Батцогтод сануулах, Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч С.Мөнхбаяр, мөн аймгийн Баяндай сумын Засаг дарга Л.Батбаатар нарт албан тушаал бурууулах, цалин хасах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан аж. Мөн Төв аймгийн

Сэргэлэн сумын дунд сургуулийн захирал И.Отгон-Эрдэнийг үүрэгт ажлаас нь чөлөөлжээ. Эрхэлсэн комиссар Т.Баярхүү мэдээлэлдээ “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нь өөрийн хамаарал бүхий хүнийг ажилд авахдаа хуульд заасан мэдэгдэл тайлбар гаргах үүргээ биелүүлээгүй тул тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор сануулах сахилгын шийтгэл тооцууллаа. Түүнчлэн Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын удирдах албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан хандив нэрээр компаниудаас бэлэн мөнгө авч хууль бусаар зарцуулсан асуудалд шинээр хэрэг үүсгэлээ. “Монре даатгал” ХХК-ийн удирдах албан тушаалтан даатгалд хамаарах бичиг баримтуудыг хуурамчаар үйлдэж, удаа дараагийн үйлдлээр 420 сая 61 мянга 797 төгрөгийн хохирлыг учруулсныг мөрдөн шалгаж эхэлсэн” гэв. Мөн нэр бүхий сайд нарт холбоотой гомдол ч АТГ-т ирсэн аж. Тухайлбал, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн болон түүний хамаарал бүхий удирдлагууд эрчим хүчний салбарт зарласан 5.8 тэрбумын тендерийг хувьдаа завшсан, хувийн компанид давуу эрхээр олгосон байж болзошгүй нөхцөл байдал үүссэнийг шалгаж байна хэмээлээ.

Гишүүний зөвлөх улсад онц их хэмжээний хохирол учруулжээ

АТГ өнгөрсөн нэг сарын хугацаанд цөөнгүй авлига, албан тушаалын хэргийг шалгаж эхэлсэн байна. Тухайлбал, Улсын тусгай хамгаалалттай газрын албан тушаалтан Ц гэгч нь эрх мэдэл албан тушаалаа урвуулан ашиглаж, байгалийн цогцолбор газарт амрагч, аялагчдаас оруулсан орлогоос тодорхой хувийг завшсан, зөвшөөрөлгүй тээвэрлэж, хураасан

модыг бусдад худалдаж завшсан, байгалийн цогцолбор газарт ойд мод арчилгааны зориулалтаар мэргэжлийн байгууллагын дунд тендер зарлалгүйгээр хувь хүмүүст мод бэлтгэлийн ажлыг олгож, хууль бусаар бэлтгүүлсэн хэргийг шалгаж байгаа аж. Мөн “МИАТ” ТӨХК-ийн удирдах албан тушаалтнууд нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлжээ. УИХ-ын гишүүний зөвлөхөөр ажиллаж байсан Т гэх залуу улсын төсвийн хөрөнгөөр 2011, 2012 онд санхүүжигдэх ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт өөрийн хамаарал бүхий компаниудын нэр дээр тендерийн бичиг баримт бүрдүүлэн оролцож, үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан хэргийг шүүхэд шилжүүлэхээр болжээ. Харин УИХ-ын гишүүн асан, Барилга хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгийн “Алтай” хотхоноос их хэмжээний мөнгө хувьдаа завшсан хэргийг шүүхэд шилжүүлсэн бол мөн л Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байсан Р.Эрдэнэбүрэн нь ажиллах хугацаандаа өөрийн ах дүү, хамаатан садны нэр дээр “River garden» цогцолбор хотхоноос 1.141.800.000 төгрөгийн үнэтэй 344.8 мкв талбай бүхий орон сууцыг худалдан авч үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс цагаатгаж шийдвэрлэсэн талаар мэдэгдэв.

“Х.Энхжаргал даргад 19 настай охин байхгүй”

АТГ-ын дарга Х.Энхжаргалын 19 настай охин “Шарын гол”-ын уурхайн ТУЗ-ын даргаар ажиллаж байгаа

гэх мэдээллийг хуульч, өмгөөлөгч н.Пүрэвбаатар мэдээлсэн билээ. Тэгвэл энэ талаар АТГ-ын Олоннийтэй харилцах хэлтсийн мэргэжилтэн, комиссар Т.Мөнхтунгалаг тайлбар өглөө. Тэрбээр, “Х.Энхжаргалд даргад 19 настай охин байхгүй. Аль нэг компанийн ТУЗ-д ажилладаг хүүхэд ч байхгүй. Энэ бол санаатай тараасан мэдээлэл. Бидний авсан мэдээлээр хэсэг бүлэг хүмүүс АТГ-ын нэр хүндийг унагах, үйл ажиллагааг нь саармагжуулах зорилгоор санаатайгаар энэ бүхнийг хийж байгаа. Бүр цуврал мэдээлэл бэлтгэж байгаа гэсэн мэдээлэл бий. Бид энэ бүхнийг Цагдаагийн байгууллагаар шалгуулна. н.Пүрэвбаатар өмгөөлөгчийг та бүхэн хэний өмгөөлөгчөөр ажиллаж байсныг мэдэж байгаа байх. Нөгөөтэйгүүр, энэ хүн АТГ-ын гэрэгдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүнээр ажилладаг. Гэтэл энэ байгууллага АТГ-ын нэр хүндийг зориуд унагах гэсэн үйлдэл удаа дараа гаргалаа. Тиймээс цаашид бид хууль бус гүтгэлэгтэй тэмцэж, цагдаагийн байгууллагад хандана” хэмээлээ.

Э.Идэрцог: УБТЗ-ын дарга Д.Жигжиднямаад холбогдох хэргийг шалгаж байна

АТГ-т шалгаагдаж буй хэргүүдийн талаар АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Э.Идэрцог хэвлэлийн хурлын төгсгөлд мэдээлэл өгөв.

“60 тэрбум”-ын хэргийг сэргээн шалгаж эхэлсэн гэсэн. Энэ талаар мэдээлэл өгөөч?

-60 тэрбумтай холбоотой хэргийг прокурорын байгууллагаас ажлын хэсэг гараад сэргээн шалгаж эхэлсэн гэсэн. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломж алга.

-МТЗ-ын удирдлагуудад холбогдох хэрэг юу болсон бэ?
-Нэр бүхий хүмүүст холбоотой

хэргийг цагаатгасан гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Харин хилээр зугтсан асуудлыг шалгаж байна. Хэргийн нарийн процессын талаар мэдээлэл өгөх прокурорын зөвшөөрөл авч чадаагүй учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй.

“Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой хэргийг шалгаж байгаа юу. Арбитрын шүүхийн сүүлд гаргасан дүгнэлтээс үүдэж хэрэг мөрдөн байцаалтад өөрчлөлт орох уу. Нийт хэчнээн хүнийг шалгаж байна вэ?

“Эрдэнэт” үйлдвэрийн асуудлыг үргэлжлүүлэн шалгасан хэвээр байна. Эдийн засгийн талаас нь аудитын дүгнэлт гарсан. Мөн энэ хэрэгт холбогдуулж 10 гаруй хавтаст хэрэг бүртгэгдсэн. Нэгтгэж шалгах гэх мэтээр асуудал их байна. Гэхдээ ойрын үед шүүхэд шилжүүлж байх. Энэ хэрэгт холбоотой хүмүүсийн талаар мэдээлэл өгөх боломжгүй. “Стандарт” банкинд барьцаанд тавьсан гэх “Жаст” группын удирдлага болон “Эрдэнэт” үйлдвэрийн тухайн үеийн удирдлагуудыг мөн шалгаж байгаа.

-МУИС-ийн удирдлагуудыг хууль бусаар төлбөрөө нэмсэн гэх үндэслэлээр шалгуулж байгаа гэдэг мэдээлэл үнэн үү. Их, дээд сургууль болон сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай холбоотой гомдол ирсэн үү?

-МУИС-ийн хэсэг багш нарын зүгээс ийм гомдол ирснийг шалгаж байгаа. Авлига авсан гэх сургууль, цэцэрлэгийн багштай холбоотой гомдол одоогоор ирээгүй байна.

-Оюутолгойн татварын асуудлыг шалгах ажил ямар шатандаа явж байна вэ?

-УИХ-аас ажлын хэсэг гараад шалгаж байгаа. Манай дээр ч асуудлыг хянаж байна.

-Д.Жигжиднямаа даргын төрсөн дүү нь оффшор бүсэд компанитай байсан, тэндээс төрсөн ахдаа мөнгө шилжүүлсэн гэх үндэслэлээр шалгаж байгаа гэх мэдээлэл үнэн үү?

-УБТЗ-ын даргад холбогдох хэргийг АТГ-т шалгаж байна. Хяналт, шалгалтын ажил үргэлжилж байгаа.

МЭДЭЭЛЭЛ

Б.Лхагва: ШӨХТГ шатахуун импортлогчдыг шалгах эрхгүй

Б.ӨНӨРТӨГТОХ

ШӨХТГ-ын газраас цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Тус байгууллага энэ сарын 01-ний байдлаар 122 хэрэглэгчийн 13 сая 753 мянган төгрөгийн хохирлыг барагдуулжээ. Сүүлийн үед шалтгаангүйгээр шатахууны үнэ нэмэгдэж байгаа асуудалд тайлбар өгсөн юм. ШӨХТГ-ын дарга Б.Лхагва “Шатахууны үнэ нэмэгдэж, зарим бараа бүтээгдэхүүний үнэд өөрчлөлт орсон нь иргэд, хэрэглэгчдийн бухимдлыг төрүүлж байгаа. Тиймээс энэ асуудалд

ШӨХТГ холбогдох эрх үүргийнхээ дагуу хяналт шалгалт хийж байна. Оны эхэнд шатахуун импортлогчид үнээ нэмсэн асуудалд манай газрын зүгээс шалгалт хийж, холбогдох ААН байгууллагуудад нийтдээ 55 сая төгрөгийн торгууль тавьсан. Нийт 10 аж ахуй байгууллагаас тав нь зөрчлөө хүлээж торгуулиа төлсөн. Харин “Сод монгол”, “Шунхлай”, “Тэс Петролиум”, “Ойн бирж” ХХК, “Жэй-Эм ойл” компаниудын асуудал шүүхээр шийдвэрлэгдсэн. ШӨХТГ нь Өрсөлдөөний тухай хуулийн дагуу шатахуун импортлогчдыг үгсэн хуйвалдаж үнэ нэмлээ гэж хэлэж

мөн шалгах эрхгүй. Шатахууны үнийн асуудлыг Ашигт малтмал газрын тосны газар хариуцсан. Тэндээс биржийн үнийг судалж мөн шатахуун импортлогчдын үнийг хянаж ажилладаг. Тус газар нь хуулийнхаа хүрээнд манай байгууллагад биржийн үнэ болон ОХУ-аас нийлүүлэгдэж буй бараа бүтээгдэхүүний үнэ ямар түвшинд байгаа талаар бидэнд мэдээлэл өгч байна. ШӨХТГ холбогдох мэргэжлийн байгууллагын судалгаанд тулгуурлан хяналт шалгалт явуулдаг” гэсэн юм.

Сураггүй алга болсон иргэнийг хайж байна

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

Энэ сарын 26-ны өдрийн 03:00-06:00 цагийн хооронд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Улаан сайр багийн “Цагаан сайрын булан” гэдэг газар Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын харьяат, иргэн Б (49 настай, эрэгтэй) сураггүй алга болж, усанд живсэн байж болзошгүй дуудлага тухайн өдрийн 14:15 цагт тус аймгийн Онцгой байдалын албанд иржээ. Дуудлагын дагуу Баянхонгор аймгийн Онцгой

байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 16 дугаар ангийн зургаан алба хаагч, нэг автомашин, сумын нутгийн захиргааны байгууллагын дэмжлэгтэйгээр эрэн хайх ажлыг явуулсан аж. “ХОТУ” ХХК-ийн алтны уурхай, “Цагаан сайрын гарам”-аас голын эрэг дагуу хоёр км-ын тойрогт эрэн хайх ажиллагаа зохион байгуулсан аж. Сураггүй алга болсон иргэнийг эрэн хайх ажил үргэлжилсээр байгаа юм байна.

